



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/209

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих, стратеги боловсруулах чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар удирдуулсан багийн үйл ажиллагааны зардалд 10,101,800 төгрөг (Арван сая нэг зуун нэг мянга найман зуу)-ийг баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 10,101,800 төгрөг (арван сая нэг зуун нэг мянга найман зуу)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ